

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн  
Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн  
хамтарсан тушаал, захирамж

1997 оны 10-р сарын  
10-ны өдөр

Дугаар А/329, А-195

Улаанбаатар хот

Нийслэлийн түргэн тусламжийн автобаазын  
үйлчилгээг өргөтгөн зохион байгуулах талаар  
авах зарим арга хэмжээний тухай:

1. Нийслэлийн Эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллагуудын тээврийн  
ажил үйлчилгээг нэгдсэн зохион байгуулалтад оруулах зорилгоор Нийслэлийн түргэн  
тусламжийн автобаазыг орлогоороо зарлагая нөхөж, аж ахуйн тооцоон дээр ажиллах  
түргэн тусламжийн, Нийгмийн халамжийн үйлчилгээ гэсэн хоёр хэсэгтэйгээр  
Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз (УҮГ) болгон өөрчлөн зохион  
байгуулахыг Нийслэлийн Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (н. Хадхүү),  
Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (н. Тэрбиш),  
Нийслэлийн халамжийн алба (н. Ордэнэбаатар) д зөвшөөрсүгэй.

2. "Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз (УҮГ)-ын дүрмийг  
хавсралт ёсоор баталсугай.

3. Ийнхүү улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн шугамаар олгосон  
автомашинны ашиглалт, үйлчилгээний талаар тогтмол мэдээлж байхын зэрэгцээ  
нийгмийн халамжийн зориулалтын ажил, тээврийн үйлчилгээний үнэ тарифыг  
Нийслэлийн үнийн зөвшилтийн комисс, Нийгмийн бодлогын хэлтэстэй зөвшилцөн  
баталж мөрдөхийг Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз (н. Лхамтүнд  
) д үүрэг болгосугай.

4. Энэ тушаал, захирамж гарч байгаатай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн  
хамгааллын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн  
1996 оны А/ 176, А/ 186 тоот тушаал, захирамжийн 2 дугаар заалтыг хүчингүй  
болгонд тооцсугай.





"Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар (УҮГ) -ын дүрэм

### Нэг. Нийтлэг үндэслэл

11 Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз / цаашид автобааз гэнэ / нь Нийслэлийн хүн амд үзүүлэх насанд хүрэгсэд, хүүхэд, халдварт, алсын яаралтай түргэн тусламж болон Нийслэлийн нийгмийн халамж, эрүүл мэндийн байгууллагуудын тээврийн үйлчилгээг зориулалтын автомашинаар дэлгэн үйлчлэх аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар (УҮГ) мөн.

12 Нийслэлийн хүн амд үзүүлэх яаралтай түргэн тусламж болон нийгмийн халамж, эрүүл мэндийн байгууллагын тээврийн үйлчилгээ эрхлэх үндсэн зорилго бүхий үйл ажиллагаа явуулах "НТТХАБ" нэртэй төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.

13 Автобааз нь улсын татварын байгууллагал бүртгүүлж, улсын гэрчилгээ авсан өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулах бөгөөд нийслэлийн хүн амд үзүүлэх яаралтай түргэн тусламжийг зориулалтын, нийгмийн халамж, эрүүл мэндийн байгууллагуудыг үйлчилгээний автомашинаар үйлчлэх үүргийг Нийслэлийн Засаг дарга болон Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Нийгмийн халамжийн албаны өмнө бүрэн хариуцна.

14 Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз нь Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт оршино.

### Хоёр. Эрх хэмжээ

21 "НТТХАБ" үйлдвэрийн газар энэхүү дүрэмд заасан болон хуулиар эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, шүүх арбитрын шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох эрхтэй.

22 Тус автобааз нь ашигт ажиллагааны зорилгот түвшинг тодорхойлсон урт болон ойрын хугацааны бизнес төлөвлөгөөг Нийслэлийн Засаг даргаар батлуудан удирдамж болгон ажиллана.

23 Үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардагдах түүхий эд материалаа бие даан элгэх, үйлдвэрлэл үйлчилгээнийхээ борлуулалтыг хариуцна.

24 Төрийн эзэмшилд байгаа төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль" -д заасан журам, Нийслэлийн Засаг дарга болон Нийслэлийн Төрийн өмчийн газрын шийдвэрийг удирдлага болгоно.

25 Үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас батлагдсан нормативын дагуу өөрт үлдээж захиран зарцуулна.

26 " НТТХАБ " үйлдвэрийн газар нь өөрийн тэмдэг, билэгдэл, бичгийн хэвлэмэл хуудастай байна.

### Гурав. Үйл ажиллагааны чиглэл

31 " НТТХАБ " аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэх доорхи үйл ажиллагааг явуулна. Үүнд:

а/ Нийслэлийн хүн амд түргэн тусламжийн автомашинаар үйлчлэх,

б/ Нийслэлийн нийгмийн халамж, эмнэлэг, сувиллын тээврийн үйлчилгээ,

32 Үйлдвэрлэл үйлчилгээний талар, сахилга, хариуцлагыг хангаж ажиллана.

33 Үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөтгөх чиглэлээр өөр төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх тохиолдолд тухай бүр нь холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэр ( зөвшөөрөл )- ийг авна.

### Дөрөв. Дүрмийн сан.

41 " НТТХАБ " аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийн сан дан ганц төрийн өмчийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд нийт хэмжээ нь 262.048.2 сан төгрөг болно. Үүнд:

|                      |   |          |
|----------------------|---|----------|
| а/ Үндсэн хөрөнгө    | - | 233156.0 |
| б/ Эргэлтийн хөрөнгө | - | 28.892.2 |

42 Дүрмийн сангийн хэмжээг өөрчлөх шаардлагатай тохиолдолд Төрийн өмчийн хорооны шийдвэрийг удирдлага болгоно.

### Тав. Удирдлага

51 " НТТХАБ " үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Захирал ( дарга ) удирдана.

52 Захирал нь Хотын өмчийн газартай гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана:

- энэхүү дүрэмд тусгагдсан эрх, үүрэг үйлдвэрийн газрын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд хүрэх түвшин
- техник технологийг шинэчлэх даалгавар
- хамт олны хөдөлмөр, нийгэм хангамжийн талаар авах арга хэмжээ
- менежментийн бодлого
- захирал болон төрийн төлөөллийн байгууллагын хариуцан хүлээх үүрэг
- үйлдвэрт өмчлөгчөөс олгосон эд хөрөнгө, түүний хэмжээ
- цалин нэмэгдэл хөлс, урамшуулал
- ажлын нөхцөл, нийгмийн асуудал
- эд хөрөнгийн хариуцлага
- гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, түүний хугацаа
- бусад нөхцөлүүд

### 5.3 Захирал нь дараах эрх үүрэгтэй

а/ Эрх: - Үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, өөрийн байгууллагын өмч хариуцагчид итгэмжлэл олгох,

- Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг хууль, гэрээ, дүрэмд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах,

- Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож батлуулах, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, Төрийн өмчийн хорооноос тогтоосон цалингийн бүдүүвч, сангийн хэмжээнд цалин тогтоох, шагналыг урамшууллын журмыг тогтоон мөрдөх,

- Удсаас хатуу тогтоосоноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг тогтоох

- Эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газарт даган мөрдөх тушаал, заавар гаргах

### б/ Үүрэг:

- Захирал нь автобаазын нэрийн өмнөөс гадаад, дотоодын бусад байгууллага, иргэдтэй байгууллагыг төлөөлөн гэрээ хэлцэл байгуулан харцах,

- Эдийн засаг, технологийн бодлого, хэтийн төлөв үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тусгасан зорилтот бизнес төлөвлөгөөг холбогдох газруудтай хамтран боловсруулах ажлыг зохион байгуулж Хотын өмчийн газраар батлуулан биелэлтийг хангах

- Боловсон хүчний бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх

- Хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлэх

- Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулан тэдгээрийн үнэн зөвийг хариуцах

- Гадаадад томилолтоор ажиллах төсөв, удирдамжаа ЭМНХЯ болон Нийслэлийн Засаг даргын холбогдох газар, хэлтсээр хянуулж батлуулах ба тайлагнах,

5.4 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлогтой холбоотой бусад эрх үүргийг захиралд эдлүүлэх талаар гэрээнд тусгана.

5.5 Захирал шаардлагатай мэргэжилтэн албан тушаалтныг оролцуулан захирлын зөвлөл байгуулах ба түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар батлана.

5.6 Захирал гэм буруутай үйл ажиллагаагаар хууль гэрээнд заасан эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

### Зургаа. Эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа.

#### бүртгэл ба хяналт

6.1 Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз нь орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар аж ахуйн тооцоон дээр ажиллана.

6.2 Нийслэлийн түргэн тусламж, халамжийн автобааз (УҮГ) нь эдийн засгийн үйл ажиллагаа нь жил бүрийн үйлшвэрлэл, үйлчилгээ түүний үр ашиг, орлогыг тодорхой тусгаж, зохих газруудаар барлагдсан зорилтот бизнес төлөвлөгөөний дагуу явагдана.

6.3 Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

6.4 Эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу ногдол ашгийн тодорхой хувийг тухайн улирлын үйл ажиллагааны үр дүнийн дэвэр ашгаас тооцон Нийслэлийн өмчийн газрын дэлсэлд оруулна.

6.5 Нийслэл хот нь түргэн тусламж, нийгмийн халамж үйлчилгээний автомашины нөхөн хангалтад зориулан жил болон хэтийн төлөвлөгөө төсөлд тусгаж, орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт олгоно.

6.6 Анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Хотын өмчийн газар, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

6.7 Тогтоосон журам, загварын дагуу Хотын өмчийн газарт мэдээ тайланг гаргаж, хугацаанд нь хүргүүлэх үүрэгтэй.

6.8 Ерөнхий нягтлан бодогч нь мэргэжсэн байх бөгөөд түүнийг Нийслэлийн санхүүгийн хэлтэстэй зөвшилцсөний үндсэн дээр захирал ( дарга ) томилно.

6.9 Захирал өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд тавих өдөр тутмын дотоод хяналтыг зохион байгуулж үр дүнг хариуцна.

6.10 Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна.

6.11 Төрийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл чанар бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий тушаалтаны шийдвэрээр тавьж олгох үүргийг захирлын тушаалаар томилогдсон эд хариуцагч хүлээнэ.

6.12 Эд хөрөнгийн дотоод тооллогыг зохих болтгэлийг хангасны үндсэн дээр " Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулинд заасан журмын дагуу үйлдвэрийн газрын захиргаа явуулж тайлан тэнцэлд тусгана.

### Долгоо. Өөрчлөх, татан буулгах

71 Эрүүл мэнд нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улианбаатар хотын захирагчийн хамтарсан тушаал захирамж болон шийдвэрээр " НТГХАБ " үйлдвэрийн газрыг өөрчлөх ба татан буулгана.

72 Үйлдвэрийн газрыг татан буулгахад Иргэний хууль болон бусад хуулийн үндэслэл журмыг баримтлана.